ТЭНГЭР ДААТГАЛ

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

# 2025

ТЭНГЭР ДААТГАЛ ХК

Хурлын материал 2025.03.06

# АГУУЛГА


| | |
|---|---|
| Хурлын зар | 04 |
| Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа | 05 |
| Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн | 05 |
| Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол | 06 |
| Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн | 08 |
| Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг | 09 |
| Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах; | 10 |
| Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох; | 11 |
| Тогтоолын төсөл | 22 |
| Саналын хуудас | 25 |
| Итгэмжлэлийн загвар | 31 |

# ХУРЛЫН ЗАР

Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид "Ээлжит бус хурал” гэх)-ыг 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутаас Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдах тул та бүхэн хуралдаа идэвхтэй оролцоорой.

Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn сайтаар хүлээн авна.

Ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

1.1 Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлуулах;
1.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв батлах;
1.3 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;

Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2025 оны 02 сарын 13-ны өдөр (цаашид “Бүртгэлийн өдөр” гэх) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон Хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь Ээлжит бус хуралд өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200 Монгол улс хаягаар болон Тооллогын комиссоор дамжуулан Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, Гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл байна.

Ээлжит бус хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

| № | Комиссын гишүүдийн нэрс | Утасны дугаар | Шуудангийн хаяг |
|---|---|---|---|
| 1 | Б.Энхтүвшин | 75001889, 99034515 | enkhtuvshin.b@tengerinsurance.mn |

| | |
|---|---|
| Ажиллах цагийн хуваарь: | Ажлын өдрүүдэд 9:00–17:00 цагийн хооронд ажиллана. |
| Компанийн хаяг: | Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж-5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200, Монгол улс |
| Имэйл: | enkhtuvshin.b@tengerinsurance.mn |
| Утас: | 7500-1889 |

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 01 сарын 25-ны өдрөөс эхлэн 03 сарын 06-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 17:00 цагийн хооронд “Тэнгэр Даатгал” ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээр очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

01 Хурлын зар;
02 Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
03 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
04 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол;
05 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
06 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг;
07 Компанийн шинэчлэгдсэн дүрэм;
08 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн материал;
09 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв;
10 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн материал.
11 Тогтоолын төсөл;
12 Саналын хуудас;
13 Итгэмжлэлийн загвар.

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Зохион байгуулах комиссын дарга: | Б.Энхтүвшин (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) |
| Зохион байгуулах комиссын гишүүд: | Т.Анхзаяа (Маркетинг хариуцсан ахлах менежер)<br>Т.Батмагнай (Хуульч)<br>Ж.Ууганбилэг (Хууль, хянан нийцлийн мэргэжилтэн) |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТЭНГЭР ДААТГАЛ

2025 оны 01 сарын 24 өдөр | № BR 25/...... | Улаанбаатар

**“ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.5 дах хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дох хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон, “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 6.3-р зүйлийн 6.3.1, 6.3.4 болон 6.3.7 дах хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12:00 цагаас Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хэрэгжүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
   3.1 Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлуулах;
   3.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төсөв батлах;
   3.3 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 сарын 13-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2025 оны 02 сарын 06-ны өдөр болон 2025 оны 02 сарын 19-ний өдрүүдэд өдөр тутмын сонинд, Компанийн www.tengerdaatgal.mn вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар 2025 оны 01 сарын 29-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар

Сити Центр 11 давхар
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Лавлах: +(976) 1800-1889
Утас: +(976) 7500-1889
Вэб: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

# "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12 цаг 00 минут хүртэл байна.

8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 01 сарын 27-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.

9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 02 сарын 01-ний өдрийн дотор Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Шаравпэлжээ овогтой Гантуяаг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-өөр баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-аар баталсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг **Хавсралт №6**-аар баталсугай.

14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш. ГАНТУЯА

# "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТЭНГЭР ДААТГАЛ

2025 оны 01 сарын 24 өдөр    № BR 25/......    Улаанбаатар

**"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Тооллогын комисс томилох тухай

"Тэнгэр Даатгал" ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

   Комиссын дарга: Т.Батмагнай (Хуульч)
   Гишүүн: Ж.Ууганбилэг (Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн)

2. Тооллогын комисс (Т.Батмагнай)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:

   a) Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
   b) Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
   c) Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах, аливаа асуултад тайлбар өгөх;
   d) Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
   e) Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
   f) Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай Тооллогын комиссын шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
   g) Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА    Ш. ГАНТУЯА

Сити Центр 11 давхар
Б.Алтангэрэлийн гудамж-5,
Ш/х-48/258, Улаанбаатар 14200,
Монгол улс

Лавлах: +(976) 1800-1889
Утас: +(976) 7500-1889
Вэб: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

| Хугацаа | Хөтөлбөр | Хариуцагч |
|---|---|---|
| 12:00 - 12:10 | Хурлын ирц бүртгэх | Тооллогын комисс |
| 12:10 - 12:15 | Хурлын ирцийг мэдээлэх | Тооллогын комисс |
| 12:15 – 12:20 | Хурлын дэгийг танилцуулна | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 12:20 - 12:25 | Хурлын дарга хурлыг нээж үг хэлнэ | Хурлын дарга - Ш.Гантуяа |
| 12:25 - 12:35 | Компанийн шинэчлэгдсэн дүрэм | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 12:35 - 12:40 | Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулах | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 12:40 - 13:00 | Компанийн ердийн болон хараат бус гишүүдийг танилцуулах; | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 13:00 - 13:20 | Асуулт хариулт | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 13:20 - 13:25 | Санал хураалт | Тооллогын комисс |
| 13:25 – 13:40 | Хурлын завсарлага, санал тоолох | Тооллогын комисс |
| 13:40 – 13:50 | Санал хураалтын дүнг танилцуулах | Тооллогын комисс |
| 13:50 - 14:00 | Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах | Хурлын дарга Ш.Гантуяа |
| 14:00 - 14:05 | Хурлын дарга хурлыг хааж үг хэлнэ | Хурлын дарга - Ш.Гантуяа |

# "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын төсөв | Нийт зардал /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал | 274,000,000 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал | 20,000,000 |
| 3 | Бичиг хэрэг болон бусад | 6,000,000 |
| 4 | Дүн | 300,000,000 |

## “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС  ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

**01** Шаравпэлжээ овогтой Гантуяа

**02** Түмэннасан овогтой Батзул

**03** Жуков овогтой Баатарболд

**04** Дорж овогтой Нямрэнцэн

**05** Бадарч овогтой Батхишиг

**06** Ганбат овогтой Ганзориг

**07** Цэвэгмид овогтой Түмэнцогт

**08** Ринчинням овогтой Амаржаргал

**09** Жамсрандорж овогтой Дэлгэрсайхан

**10** Галзагд овогтой Туул

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Шаравпэлжээ ГАНТУЯА**

**Төрсөн он:** 1982

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Жоржтаун их сургууль | АНУ | 2007 | 2008 | Олон улсын бизнес удирдлага |
| 2 | Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль | Улаанбаатар | 1998 | 2002 | Бизнес удирдлага Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Тэнгэр Даатгал” ХК | ТУЗ-ийн дарга | 2022 - одоо |
| 2 | “Мандал Даатгал” ХК | ТУЗ-ийн гишүүн | 2021 - одоо |
| 3 | “Мандал Санхүүгийн нэгдэл” ХХК | Маркетинг хариуцсан захирал | 2013 - одоо |
| 4 | “Монгол Ньюс” ХХК | Маркетингийн хэлтсийн захирал | 2008 - 2011 |
| 5 | “Улаанбаатар зочид буудал”ХХК | Маркетингийн албаны дарга | 2003 - 2007 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Түмэннасан БАТЗУЛ**

**Төрсөн он:** 1980

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Уэйлсийн их сургууль | Австрали | 2007 | 2009 | Олон улсын бизнес удирдлага |
| 2 | Сэрүүлэг их сургууль | Улаанбаатар | 1998 | 2001 | Бизнесийн удирдлага Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Тэнгэр Даатгал” ХК | ТУЗ-ийн гишүүн | 2022 - одоо |
| 2 | “Мандал Даатгал” ХК | ТУЗ-ийн гишүүн | 2021 - одоо |
| 3 | “Хай пэймэнт солюшнс” ХХК | Зөвлөх | 2021 - 2022 |
| 4 | “Мандал Ассет Менежмент” ҮЦК | Зөвлөх | 2021 - 2022 |
| 5 | “Мандал Капитал Маркетс” ҮЦК | Зөвлөх | 2021 - 2022 |
| 6 | “Эрдэнэ Монгол” ХХК | Зөвлөх | 2021 - 2022 |
| 7 | Монгол Улсын Их Хурал | Албан ёсны зөвлөх | 2020 - 2022 |
| 8 | “Голомт банк” ХХК | Газрын захирал | 2015 - 2019 |
| 9 | “Мандал Даатгал” ХХК | Захирал | 2011 - 2014 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Жуков БААТАРБОЛД**

**Төрсөн он:** 1982

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Льюксембургийн их сургууль | Льюксембург | 2014 | 2016 | Банк, санхүүч Магистр |
| 2 | Санхүү Эдийн Засгийн их сургууль | Улаанбаатар | 2000 | 2004 | Банк, санхүүч Магистр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Си Эм Ай Академи” ХХК | Гүйцэтгэх захирал | 2024 - одоо |
| 2 | “Тэнгэр Даатгал” ХХК | Гүйцэтгэх захирал | 2023 - 2024 |
| 3 | “Тэнгэр Даатгал” ХХК | Иргэдийн даатгал хариуцсан захирал | 2020 - 2023 |
| 4 | “Хас банк” ХХК | Салбарын удирдлагын хэлтсийн захирал | 2015 - 2020 |
| 5 | “Хас банк” ХХК | Харилцагчийн удирдлагын хэлтсийн захирал | 2014 - 2014 |
| 6 | “Хас банк” ХХК | Салбарын удирдлагын хэлтсийн захирал | 2013 - 2014 |
| 7 | “Хас банк” ХХК | Бүсийн захирал | 2008 - 2013 |
| 8 | “Хас банк” ХХК | Салбарын захирал | 2007 - 2008 |
| 9 | “Хас банк” ХХК | Бүсийн менежер | 2006 - 2007 |
| 10 | “Хас банк” ХХК | Жижиг дунд бизнесийн зээлийн мэргэжилтэн | 2004 - 2006 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Дорж НЯМРЭНЦЭН**

**Төрсөн он:** 1974

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | МУИС – Хууль зүйн сургууль | Улаанбаатар | 2000 | 2004 | Эрх зүйч Бакалавр |
| 2 | МУИС – Эдийн засгийн сургууль | Улаанбаатар | 1992 | 1997 | Эдийн засагч Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Бүрэн” Групп | ТУЗ-ийн дарга | 2023 - одоо |
| 2 | “Худалдаа хөгжлийн банк” ХХК | Гүйцэтгэх захирлын орлогч | 1997-2022 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Дорж НЯМРЭНЦЭН**

**Төрсөн он:** 1974

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | 40-р сургууль | Улаанбаатар | 1982 | 1992 | Бүрэн дунд |
| 2 | МУИС-ЭЗС | Улаанбаатар | 1992 | 1997 | Эдийн засагч - бакалавр |
| 3 | МУИС-ОУХС | Улаанбаатар | 1998 | 2000 | Англи хэлний багш, орчуулагч - бакалавр |
| 4 | Япон улсын Хөгжлийн банк | Япон | 2000 | 2000 | Акийн эдийн засгийн загварчлал |
| 5 | МУИС-ЭЗС | Улаанбаатар | 2001 | 2003 | Бизнесийн удирдлагын магистр |
| 6 | Кредит Иншталь банк | Австри | 2002 | 2002 | Хөрөнгө оруулалтын төслийн зээлийн эдийн засагч |
| 7 | Калифорнийн их сургууль | АНУ | 2005 | 2005 | Худалдааны санхүүжилт |
| 8 | МУИС-ХЗС | Улаанбаатар | 2005 | 2008 | Эрх зүйч - бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Бүрэн Групп | ТУЗ-ийн дарга | 2023 - одоо |
| 2 | Кидан ХЗХ | ТУЗ-ийн гишүүн | 2022 - одоо |
| 3 | Бүрэнфинанс ББСБ | ТУЗ-ийн дарга | 2022 - одоо |
| 4 | “Худалдаа хөгжлийн банк” ХК | Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч | 2018-2022 |
| 5 | Худалдаа, хөгжлийн банк, Байгууллагын банкны газар | Зээл хариуцсан орлогч захирал | 2007-2018 |
| 6 | Худалдаа, хөгжлийн банк, Байгууллагын банкны газар | Ахлах зээлийн эдийн засагч | 2003-2007 |
| 7 | Худалдаа, хөгжлийн банк, Зээлийн газар | Зээлийн эдийн засагч | 2000-2003 |
| 8 | Худалдаа, хөгжлийн банк, Энхтайван салбар | Ерөнхий ня-бо | 1997-2000 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Бадарч БАТХИШИГ**

**Төрсөн он:** 1990

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мишкольц их сургууль | Унгар | 2016 | 2018 | Бизнесийн удирдлага Магистр |
| 2 | Санхүү эдийн засгийн их сургууль | Улаанбаатар | 2008 | 2012 | Бизнесийн эдийн засагч Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Мандал Санхүүгийн Нэгдэл” ХХК | Гүйцэтгэх захирал | 2023 - одоо |
| 2 | “Мандал Ассет Менежмент” ҮЦК | Дэд захирал | 2021 - 2023 |
| 3 | “Ньюком” Групп | Ахлах шинжээч | 2018 - 2021 |
| 4 | “Мандал Даатгал” ХХК | Шинжээч | 2012 - 2016 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Ганбат ГАНЗОРИГ**

**Төрсөн он:** 1991

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Лийдсийн их сургууль | Англи | 2015 | 2016 | Эдийн засагч Магистр |
| 2 | Санхүү эдийн засгийн их сургууль | Улаанбаатар | 2009 | 2013 | Бизнесийн удирдлагын Бакалавр |

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Мандал Капитал Маркетс” ҮЦК | Ерөнхий захирал | 2023 - одоо |
| 2 | “Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын ХОС | Гүйцэтгэх захирал | 2021 - одоо |
| 3 | “Мандал Ассет Менежмент” ҮЦК | Гүйцэтгэх захирал | 2021 - 2023 |
| 4 | “Мандал Даатгал” ХК | Хөрөнгө оруулалт хариуцсан захирал | 2020 - 2021 |
| 5 | “Голомт банк” ХХК | Ахлах шинжээч | 2016 - 2020 |

# "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Цэвэгмид ТҮМЭНЦОГТ**

**Төрсөн он:** 1968

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

## БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Москвагийн эрчим хүчний инженерийн дээд сургууль | ОХУ | 1986 | 1993 | Эрчим хүчний Магистр |
| 2 | Индианагийн их сургууль | АНУ | 1999 | 2001 | Төрийн удирдлагын Магистр |

## АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | "Project Management Institute" (PMI) Олон улсын ТББ | Монгол дахь салбарын Ерөнхийлөгч | 2021 - одоо |
| 2 | "Монголын Бизнесийн Зөвлөл" ТББ | Удирдах зөвлөлийн дарга | 2020 - одоо |
| 3 | "Эрдэнэс Оюу Толгой" ХХК | Гүйцэтгэх захирал | 2019 - 2021 |
| 4 | "Оюу Толгой" ХХК | ТУЗ-ийн гишүүн | 2018 - 2020 |
| 5 | "Эрдэнэс Монгол" ХХК | Гүйцэтгэх захирал | 2016 - 2018 |
| 6 | АНУ-ын "Женерал электрик" компани | Монгол дахь Суурин төлөөлөгч, Гүйцэтгэх захирал | 2011 - 2016 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Ринчиннямийн АМАРЖАРГАЛ**

**Төрсөн он:** 1968

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Брэдфордын Их Сургууль | Их Британи | 1993 | 1994 | Хөгжлийн эдийн засагч Магистр |
| 2 | УАААДС, Москва | ЗХУ | 1978 | 1982 | Эдийн засагч Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | “Санхүү, Эдийн засгийн их сургууль” | Ерөнхий захирал, Ректор, Удирдах зөвлөлийн дарга | 2017 - одоо |
| 2 | “Монгол улсын Их Хурал” | Гишүүн | 1996, 2004, 2008, 2012 - 2016 |
| 3 | “Монгол улсын Засгийн газар” | Ерөнхий сайд | 1999 - 2000 |
| 4 | “Монгол улсын Засгийн газар” | Сайд | 1998 - 1999 |
| 5 | “Эдийн засгийн коллеж” | Захирал | 1991 - 1996 |
| 6 | “Цэргийн нэгдсэн дээд сургууль” | Багш | 1983 - 1991 |
| 7 | “Монголын Үйлвэрчний эвлэлийн Төв зөвлөл” | Зааварлагч | 1982 - 1983 |

# “ТЭНГЭР ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН**

**Төрсөн он:** 1974

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | МУИС - Хууль зүйн сургууль | Улаанбаатар | 2004 | 2006 | Эрх зүйч Бакалавр |
| 2 | СЭЗИС | Улаанбаатар | 2001 | 2003 | Санхүүгийн удирдлага Магистр |
| 3 | Хөдөө аж ахуйн их сургууль | Улаанбаатар | 1992 | 1995 | Эдийн засагч Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Төсвийн тогтвортой байдлын зөвлөл | Гишүүн | 2024 - одоо |
| 2 | “Мандал Хуримтлалын сан” | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2022 - одоо |
| 3 | “Сод Ассет Менежмент” ХХК | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2021 - одоо |
| 4 | “Зээлийн батлан даалтын сан” | Удирдах зөвлөлийн гишүүн | 2021 - 2023 |
| 5 | “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХК | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2019 - 2020 |
| 6 | “Мандал Даатгал” ХК | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2018 - одоо |
| 7 | “Худалдаа хөгжлийн банк” ХК | ТУЗ-ийн хараат бус гишүүн | 2018 - одоо |
| 8 | Монгол Улсын Их Хурлын Тамгын газар | Байнгын хорооны зөвлөх | 2018 - одоо |
| 9 | “Кибернетик” ББСБ | Дэд захирал, Зөвлөх | 2007 - 2009 |
| 10 | “Машин механизм”ХХК | Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга | 2005 - 2007 |
| 11 | “М энд Жи траст” ҮЦК | Гүйцэтгэх захирал | 1998 - 2000 |
| 12 | СЭЗИС-ийн Санхүү удирдлагын тэнхим | Багш, Тэнхимийн эрхлэгч, Дэд профессор, Зөвлөх | 1996 - одоо |

# "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН АНКЕТ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ



**Галзагд ТУУЛ**

**Төрсөн он:** 1972

**Төрсөн газар:** Улаанбаатар хот

### БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төгссөн сургууль | Байршил | Элссэн огноо | Төгссөн огноо | Эзэмшсэн мэргэжил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Колорадогийн техникийн их сургууль | АНУ | 2008 | 2010 | Санхүү, бизнесийн удирдлага Магистр |
| 2 | СЭЗИС | Улаанбаатар | 1999 | 2001 | Нягтлан бодогч Магистр |
| 3 | Компьютерын Техник Менежментийн Сургууль | Улаанбаатар | 1989 | 1993 | Компьютерын техникч, программист Бакалавр |

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Ажилсан байгууллагын нэр | Албан тушаал | Ажилсан хугацаа |
|---|---|---|---|
| 1 | "Хас банк" ХК | Эко банкны Газрын захирал | 2012 - одоо |
| 2 | "МТНД" ХХК | Гүйцэтгэх захирал | 2010 - 2012 |
| 3 | "Хас банк" ХХК | Банкны үйлчилгээний хэлтсийн захирал Улаанбаатар хотын Бүсийн захирал | 2001 - 2008 |
| 4 | "Хадгаламжийн банк" ХХК | Нэгдсэн бодлогын газар, Эдийн засагч, Дилер | 1998 - 2001 |

# ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ТЭНГЭР ДААТГАЛ

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №4-1*

**"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

*Тогтоолын төсөл*
2025 оны 03 сарын 06-ны өдөр    Дугаар 25/001    Улаанбаатар хот

**Компанийн шинэчлэгдсэн дүрэм**
**батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 03 сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралт №1 дагуу батлагсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА    Ш.ГАНТУЯА


CITY CENTER, 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж 5,
Ш/х-48/258 Улаанбаатар-14200
Монгол улс

Лавлах: +(976) 1800-1889
Утас: +(976) 7500-1889
Веб: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

# ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ТЭНГЭР ДААТГАЛ

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын 25/001 тоот тогтоолын Хавсралт №4-2*

**"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

*Тогтоолын төсөл*

2025 оны 03 сарын 06-ны өдөр Дугаар 25/002 Улаанбаатар хот

**Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дэх хэсэг болон 2025 оны 03 сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлынтэмдэглэл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай:

| № | Зардлын төсөв | Нийт зардал /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал | 274,000,000 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал | 20,000,000 |
| 3 | Бичиг хэрэг болон бусад | 6,000,000 |
| | Дүн | 300,000,000 |

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Ш.ГАНТУЯА

CITY CENTER, 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж 5,
Ш/х-48/258 Улаанбаатар-14200
Монгол улс

Лавлах: +(976) 1800-1889
Утас: +(976) 7500-1889
Веб: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

# ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ТЭНГЭР ДААТГАЛ

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №4-2*

**"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

*Тогтоолын төсөл*
2025 оны 03 сарын 06-ны өдөр Дугаар 25/003 Улаанбаатар хот

**Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын 2-р зүйлийн 2.10 дахь хэсэг, "Тэнгэр Даатгал" ХК-ийн дүрмийн 6.3-р зүйлийн 6.3.7 дэх хэсэг, 2025 оны 03 сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай:

    1. Хатагтай Ш.Гантуяа (ердийн гишүүн)
    2. Ноён Т.Батзул (ердийн гишүүн)
    3. Ноён Р.Амаржаргал (хараат бус гишүүн)
    4. Ноён Г.Туул (хараат бус гишүүн)
    5. Ноён Ц.Түмэнцогт (хараат бус гишүүн)

2. "Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд Хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай:

    1. ..................................................
    2. ..................................................
    3. ..................................................
    4. ..................................................
    5. ..................................................
    6. ..................................................

3. "Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох асуудалд Хувьцаа эзэмшигчдээс олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр 3 жилийн хугацаатайгаар сонгосугай:

    1. ..................................................
    2. ..................................................
    3. ..................................................

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Баянмөнх) болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Энхтүвшин) нарт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА Ш.ГАНТУЯА

CITY CENTER, 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж 5,
Ш/х-48/258 Улаанбаатар-14200
Монгол улс

Лавлах: +(976) 1800-1889
Утас: +(976) 7500-1889
Веб: www.tengerdaatgal.mn
И-мэйл: insurance@tengerinsurance.mn

# САНАЛЫН ХУУДАС

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №3-1*

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Компанийн нэр: "Тэнгэр Даатгал" ХК
Хурал хуралдах газар, огноо, цаг: 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минут, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдана.
Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр ................................ нэр ..................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар ........................
Регистрийн дугаар ..............................
Эзэмшиж буй хувьцааны тоо .................. төрөл ........*энгийн*..........

| № | Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно) | Хувьцаа эзэмшигчийн санал | | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | |
| 1 | Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах | | | | |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): ...........................

Огноо: 2025 оны ..... сарын ......-ны өдөр ..... цаг ..... минут

***САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:***

1. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
   - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (√) тэмдэг тавина.
   - Засварласан, балласан, (√)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг хувилбарыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
   - Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.

2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцагч брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж - 5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200, Монгол улс хаягаар 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12:00 цагийн дотор ирүүлнэ үү.

3. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.

4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

## САНАЛЫН ХУУДАС

Таныг төлөөлөх хүний:

Эцэг/эхийн нэр ……………………………… нэр ………………………………....

Таны:

Эцэг/эхийн нэр ……………………………… нэр ………………………………....

Утасны дугаар ………………………………………………………………...

Гарын үсэг ……………………………………………........

**Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгцээнд:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: ..................................................

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2025 оны ....... сар.......өдөр .... цаг .... минут

# САНАЛЫН ХУУДАС

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №3-2*

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Компанийн нэр: "Тэнгэр Даатгал" ХК
Хурал хуралдах газар, огноо, цаг: 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минут, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдана.
Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр ................................ нэр ..................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар ........................
Регистрийн дугаар ..............................
Эзэмшиж буй хувьцааны тоо ................. төрөл ........*энгийн*.........

| № | Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно) | Хувьцаа эзэмшигчийн санал | | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | |
| 1 | Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв | | | | |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): ............................

Огноо: 2025 оны ..... сарын ......-ны өдөр ..... цаг ..... минут

***САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:***

5. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
   - Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (√) тэмдэг тавина.
   - Засварласан, балласан, (√)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг хувилбарыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
   - Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.

6. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Сити центр, 11 давхар, Б.Алтангэрэлийн гудамж - 5, Ш/х-48/258, Улаанбаатар 14200, Монгол улс хаягаар 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12:00 цагийн дотор ирүүлнэ үү.

7. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.

8. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

# САНАЛЫН ХУУДАС

Таныг төлөөлөх хүний:

Эцэг/эхийн нэр ……………………………… нэр ……………………………....

Таны:

Эцэг/эхийн нэр ……………………………… нэр ……………………………....

Утасны дугаар ………………………………………………………...

Гарын үсэг ………………………………………........

**Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгцээнд:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: ..................................................

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2025 оны ....... сар.......өдөр .... цаг .... минут

# САНАЛЫН ХУУДАС

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №3-3*

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Компанийн нэр: "Тэнгэр Даатгал" ХК
Хурал хуралдах газар, огноо, цаг: 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минут, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдана.
Хувьцаа эзэмшигчийн эцэг/эхийн нэр ................................ нэр ..................................
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар ........................
Регистрийн дугаар ..............................
Эзэмшиж буй хувьцааны тоо ................. төрөл ........*энгийн*..........

| № | Батлах асуудлууд: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох (саналыг кумулятив аргаар) | Хувьцаа эзэмшигчийн санал | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|
| | | Нэр дэвшигчид өгөх саналын тоо | Татгалзсан | |
| **Ердийн гишүүн:** | | | | |
| 1 | Шаравпэлжээ овогтой Гантуяа | | | |
| 2 | Түмэннасан овогтой Батзул | | | |
| 3 | Бадарч овогтой Батхишиг | | | |
| 4 | Жуков овогтой Баатарболд | | | |
| 5 | Ганбат овогтой Ганзориг | | | |
| 6 | Дорж овогтой Нямрэнцэн | | | |
| **Хараат бус гишүүн:** | | | | |
| 1 | Галзагд овогтой Туул | | | |
| 2 | Цэвэгмид овогтой Түмэнцогт | | | |
| 3 | Жамсрандорж овогтой Дэлгэрсайхан | | | |
| 4 | Ринчинням овогтой Амаржаргал | | | |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг (тэмдэг): ...........................

Огноо: 2025 оны ..... сарын ......-ны өдөр ..... цаг ...... минут

***САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:***

1. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
   - Саналыг кумулятив аргаар тоолох асуудлын хувьд санал өгөх эрхийн тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, таны эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь 9 саналын эрхтэй байна. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл таны санал өгөх эрхийн тоо нь тус компанийн ТУЗ-ийн есөн гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү буюу 900 саналын эрхтэй байх бөгөөд та нэр дэвшигчдэд дурын харьцаагаар хуваарилан өгөх эсхүл нэг нэр дэвшигчид бүгдийг нь өгөх эрхтэй. Тиймээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг дэмжиж байгаа тохиолдолд нэр дэвшигчид өгөх саналын тоо хэсэгт өөрийн эзэмшиж буй нийт хувьцааны саналын эрхийн тоог тавина уу. Хэрвээ тус гишүүнийг сонгохоос татгалзаж байгаа тохиолдолд татгалзсан гэсэн хэсэгт (√) тэмдэглэгээг тавина.

# САНАЛЫН ХУУДАС

- Засварласан, балласан, нэр дэвшигчид өгөх саналыг тоогоор илэрхийлээгүй, санал өгсөн саналын эрхийн тоо нь нийт эзэмшиж байгаа саналын эрхийн тооноос илүү гарсан тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг саналын хуудсан дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна, эсхүл итгэмжлэлээр төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна.

2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Сити центр, 11 давхар Б.Алтангэрэлийн гудамж-5, Бага тойруу, Ш/х-48/258, Улаанбаатар 14200, Монгол улс хаягаар 2025 оны 03 сарын 05-ны өдрийн 12:00 цаг дотор ирүүлнэ үү.
3. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлындаргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.
4. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Эцэг/эхийн нэр ………………………………. нэр ……………………………....

Таны:

Эцэг/эхийн нэр ………………………………. нэр ……………………………....

Утасны дугаар ………………………………………………………...

Гарын үсэг ……………………………………….........

**Зөвхөн тооллогын комиссын албан хэрэгцээнд:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм /Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: ..................................................

Саналын хуудас тоолсон өдөр, цаг: 2025 оны ....... сар.......өдөр .... цаг .... минут

# ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

*"Тэнгэр Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн*
*2025 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын*
*25/001 тоот тогтоолын Хавсралт №6*

**2025 ОНЫ 03 САРЫН 06-НЫ ӨДРИЙН "ТЭНГЭР ДААТГАЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР**

Миний бие ..............................................................................-ны .......................................... (РД:.........................) нь "Тэнгэр Даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө дэх нэг бүр нь ............................... төгрөгийн нэрлэсэн үнэтэй ............................... ширхэг хувьцааг эзэмшдэг бөгөөд энэхүү итгэмжлэлээр ..................................................... -ны .......................................... (РД:.........................)-г 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутад, Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, Галлериа Улаанбаатар төв, 3-р давхар, "JUULCHIN SKY BALLROOM"-д хуралдах "Тэнгэр Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд миний нэрийн өмнөөс оролцох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зард тусгасан хэлэлцэх асуудал болон хурлаас гарах шийдвэртэй холбогдуулан доор заасны дагуу, хэрэв доор тусгайлан тэмдэглээгүй/заагаагүй бол өөрийн зохистой гэж үзсэний дагуу санал өгөх бүрэн эрхийг олгож, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байна.

| № | Батлах асуудлууд: (Саналыг энгийн аргаар тоолно.) | Хувьцаа эзэмшигчийн санал | | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | |
| 1 | Компанийн шинэчлэгдсэн дүрэм батлах | | | | |

| № | Батлах асуудал: (Саналыг энгийн аргаар тоолно.) | Хувьцаа эзэмшигчийн санал | | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | |
| 1 | Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв | | | | |

| № | Батлах асуудлууд: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох | Хувьцаа эзэмшигчийн санал | | Татгалзсан үндэслэл |
|---|---|---|---|---|
| | | Нэр дэвшигчид өгөх саналын тоо | Татгалзсан | |
| Ердийн гишүүн: | | | | |
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |
| 5 | | | | |
| 6 | | | | |
| Хараат бус гишүүн: | | | | |
| 1 | | | | |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | | | | |

# ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАР

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тэмдэг : ..............................................

Итгэмжлэл олгосон огноо: ..............................................

1. Хувьцаа эзэмшигч өөрийн нэр, хаяг, регистрийн дугаарыг том үсгээр бичиж оруулна уу.
2. Хувьцаа эзэмшигч өөрийн нэр дээр бүртгэлтэй, энэхүү итгэмжлэлд хамаарах хувьцааны тоог оруулна уу. Хэрэв тодорхой тоо заагаагүй бол энэхүү итгэмжлэлийг таны нэр дээрх Компанийн бүх хувьцаанд хамааруулна.
3. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, регистрийн дугаарыг оруулна уу. Нэгээс илүү итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох бол тухайн итгэмжлэлд хамаарах хувьцааны тоог оруулна уу. Хэрэв аливаа нэр заагаагүй бол Хурлын дарга таны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуралд санал өгөх болно.
4. АНХААР; Энгийн аргаар санал тоолох асуудлын хувьд л холбогдох хэсгийн "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн"-ий зөвхөн аль нэгийг (√) гэж тэмдэглэнэ үү. Саналыг кумулятив аргаар тоолох асуудлын хувьд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг дэмжиж байгаа тохиолдолд нэр дэвшигчид өгөх саналын тоо хэсэгт өөрийн эзэмшиж буй нийт хувьцааны тоог ТУЗ-ийн гишүүдийн нийт тоогоор буюу 9-р үржүүлсэн саналын эрхийн тоог тавина уу. Хэрвээ тус гишүүнийг сонгохоос татгалзаж байгаа тохиолдолд татгалзсан гэсэн хэсэгт (√) тэмдэглэгээг тавина. Аливаа тэмдэглэгээ хийгээгүй тохиолдолд таны итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн үзэмжээр Хурлаас гарах шийдвэрт санал өгөх эрхтэй болохыг анхаарна уу.
5. Хувьцаа эзэмшигч хувь хүн бол уг итгэмжлэл дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн гарын үсэг зурж компанийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

# ТЭМДЭГЛЭЛ

ТЭНГЭР ДААТГАЛ


## Холбоо барих

- 1800-1889
- insurance@tengerinsurance.mn
- Даваа-Баасан: 08:30-19:00
  Бямба, Ням: амарна
- CITY CENTER, 11 давхар СБД, 8-р хороо,
  Улаанбаатар, Монгол Улс